



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 20 өдөр

Дугаар А/ЗСЭ

Булган сум

“Согтууруулах ундаа худалдах,  
түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл” олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн 2.2 дугаар зүйлийн 2.2.1, 8.1 дүгээр зүйлийн 2 дугаар хэсгийн 12.13, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.3, 16 дугаар зүйлийн 16.1, 16.2, 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны А/04 дүгээр тушаалаар батлагдсан “Согтууруулах ундааны хариуцлагатай үйлчилгээний сургалтын журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл”-ийг шинээр олгох цэгийн нэрсийг хавсралтаар баталж, 5 жилийн хугацаатай олгосугай.

2. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2.1, 35.2.2-д заасан тэмдэгтийн хураамжийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхийг сумын Засаг дарга нар, Татварын хэлтэс (Д.Лхагвасүрэн), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Г.Давааням)-т тус тус даалгасугай.

3. Дээрх цэгүүдийн үйл ажиллагаанд холбогдох хууль, журам, стандартуудын хэрэгжилтийг хангуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар (Г.Ганбаяр Цагдаагийн дэд хурандаа), Хүнс, хөдөө аж ахуйн газар (Ч.Амгалан), Стандарт, хэмжил зүйн хэлтэс (Ц.Бүрэнтуяа), сумын Засаг дарга, аж ахуйн нэгж байгууллагын удирдлагад тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Б.АРИУН-ЭРДЭНЭ



Аймгийн Засаг даргын 2024 оны  
05 дугаар сарын 20-ны/ний өдрийн А/358 дугаар  
захирамжийн хавсралт

**“СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХ, ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ  
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ” ЭЗЭМШИХ ЦЭГИЙН НЭРС**

Д/д	Сумын нэр	Аж ахуйн нэгжийн нэр	Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн овог, нэр	Үйлчилгээний төрөл	Бар, ресторан, дэлгүүрийн нэр
1	2	3	4	5	6
1	Сайхан	Хөхүүрийн шаагаа ХХК	Ц.Долгорсүрэн	хүнсний дэлгүүр	“Дөлгөөн”
2	Хишиг-Өндөр	“Их гүн хайрхан” ХХК	Г.Төмөрчөдөр	хүнсний дэлгүүр	“Гүн хайрхан”
3	Тэшиг	“Ихэр тарвагатай” ХХК	Э.Мөнхбаяр	хүнсний дэлгүүр	“Ихэр тарвагатай”
	Нийт-3				